



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 8/14

Номгон

Мэргэжлийн зэрэг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан Спортын сайдын 2018 оны А/812 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”-ын 2 дахь хэсгийн 2.2.3, 2019 оны А/854 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэгийн багш арга зүйч, Удирдах албан тушаал эрхэлж байгаа багшид мэргэжлийн зэрэг олгох, хасах, хэвээр хадгалах журам”-ын 2.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 24-ний 252 дугаар албан бичгийг хэрэгжүүлэх зорилгоор удирдах албан тушаалд ажиллаж буй багшид мэргэжлийн зэрэг олгуулахаар тухайн сургууль, цэцэрлэгийн Заах аргын нэгдлийн хурлаар шийдвэрлэж ирүүлсэн саналыг үндэслэн Эрдэнэмандал ахлах сургуулийн захирал Л.Ононхүү, 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Э.Оюунтуяа нарт “Тэргүүлэх” мэргэжлийн зэрэг олгосугай.

2. Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 2023 оны 01 дүгээр сараас эхлэн олгож, шаардагдах хөрөнгийг тухайн байгууллагын цалингийн сангаас олгохыг холбогдох байгууллагын Нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ЭНХБАЯР